

“МАХИМПЭКС” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2024.03.15

Зөвшөөрөл олгох, үүрэг даалгавар
биелүүлэх тухай

Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын тэмдэглэлийг үндэслэн

ТОГТООХ НЬ :

1. 2023.11.23 ны өдрөөс Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнээр нөхөн сонгууль хүртэл түр томилогдсон С.Энхтуул, Ц.Эрдэнэбат нарыг нэр дэвшигчдийн бүртгэлээс хасаж, хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдах өдрөөр бүрэн эрхийг дуусгавар болгосугай.
2. Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнээр Т.Золбаяр, Б.Оргил нарыг бүртгэж, саналын хуудсанд нэрийг нь оруулахыг нэр дэвшүүлэх хороонд зөвшөөрсүгэй.
3. Хувьцаа эзэмшигч нарын хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох, санал гаргах, мэдээлэл авах зэрэг хууль ёсны эрхээ хэрэгжүүлэх бололцоо, нөхцөлийг бүрдүүлж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлөөс томилогдсон хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал зохион байгуулах комисст үүрэг болгосугай.
4. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдуулахтай холбогдсон зардлыг компани бүрэн хариуцахыг гүйцэтгэх захирал, ерөнхий нягтлан бодогч нарт даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

Г.ЦЭНГҮҮН, -

